

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 5-р сарын 23-ны байдлаар


2018 оны 5-р сарын 23-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 2.8 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.5 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 5-р сарын 23-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 3.0 хувь, үхрийн ястай махны үнэ 1.1 хувь, үхрийн цул махны үнэ 1.3 хувиар өссөн бол ямааны ястай махны үнэ 2.7 хувиар буурсан байна. Харин адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ өмнөх сараас 0.7 хувь, үхрийн ястай махны үнэ 0.7 хувь, үхрийн цул махны үнэ 0.6 хувиар өссөн бол ямааны ястай мах болон адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байлаа.

2018 оны 5-р сарын 23-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7520 төгрөг, үхрийн /ястай/ мах 8490 төгрөг, үхрийн цул мах 10210 төгрөг, адууны /ястай/ мах 6075 төгрөг, ямааны /ястай/ мах 5065 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2018 оны 5-р сарын 23-ны байдлаар савласан дээд гурилын үнэ өмнөх сараас 1-р зэргийн задгай гурилын үнэ 0.4 хувиар буурсан бол өмнөх 7 хоногтой харьцуулахад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 5-р сарын 23-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас 4.5 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сараас 0.5 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 5-р сарын 23-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 24.7 хувь, манжингийн үнэ 7.3 хувь, луувангийн үнэ 20.9 хувь, байцааны үнэ 9.5 хувиар өссөн байна. Харин сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ 24.7 хувь, луувангийн үнэ 10.2 хувь, байцааны үнэ 2.8 хувь, хүрэн манжингийн үнэ 2.0 хувь өссөн бол сонгины ногооны өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 5-р сарын 23-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 1.0 хувь, задгай сүүний үнэ 2.0 хувиар буурсан бол “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.2 хувиар өссөн байлаа. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.2 хувиар буурсан байлаа.

Ургамлын тос болон цөцгийн тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй өөрчлөлтгүй байлаа.